



ЧИНГИС ХААН
БАНК

2017 ЖИЛИЙН ТАЙЛАН

Чингис Хаан банкны танилцуулга

Мэндчилгээ

2017 оны онцлох үйл явдлууд

Компанийн засаглал

Монгол улсын эдийн засгийн орчин

Банкны санхүүгийн голлох үзүүлэлтүүд

Үйл ажиллагааны тайлан

Хараат бус аудитын тайлан

БАНКНЫ ТУХАЙ

ЭРХЭМ ЗОРИЛГО: Бид харилцагчдынхаа хэрэгцээнд тулгуурласан банк, санхүүгийн цогц үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд хүргэж, үнэ цэнийг харилцагчиддаа, хөгжил цэцэглэлтийг улс орондоо авч ирэх хамгийн найдвартай банк байх болно.

Чингис Хаан банк нь 2001 онд Монгол улсын хамгийн анхны 100 хувь гадаадын хөрөнгө оруулалттай байгуулагдаж, 2016 оноос 100 хувь үндэсний хөрөнгө оруулагчтай банк болон өөрчлөгдөн, үйл ажиллагааныхаа цар хүрээг тэлж Улаанбаатар хот, Сэлэнгэ, Өмнөговь аймгуудад шинээр нэгж байгуулан харилцагчиддаа банкны үйлчилгээгээ улам ойртуулсаар байна.

Бид аж үйлдвэр, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын томоохон төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхийн зэрэгцээ байгууллагын банк, хувийн банкны цогц үйлчилгээг харилцагчдынхаа хүсэл сонирхолд нийцсэн орчин үеийн дэвшилтэт технологид суурилсан цахим банкны үйлчилгээтэй хослуулан хүргэхийг зорьж байна.



МЭНДЧИЛГЭЭ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм танд Чингис Хаан банкны 2017 оны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүн, ололт амжилтыг тайлагнаж байгаадаа таатай байна.

Чингис Хаан банк нь хувь нийлүүлсэн хөрөнгөө тогтмол нэмэгдүүлэх стратегиа амжилттай хэрэгжүүлснээр эрсдэл даах чадвараа дээшлүүлж, активын чанарыг сайжруулан үйл ажиллагаагаа улам тогтворжуулж, Монголбанкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг тогтмол ханган ажиллаж, өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтээ сайжруулан 2018 оныг угтлаа.

2017 онд эдийн засгийн хүндрэлийг богино хугацаанд даван туулах “өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд Монгол улсын засгийн газар, Монголбанктай хамтран арилжааны банкуудад хийсэн активын чанарын үнэлгээнд манай банк амжилттай шалгагдлаа.

Цаашид банкныхаа хүчин чадлыг дээшлүүлэх, эрсдэлийг зохистой удирдах, банкны хэвийн үйл ажиллагааг бэхжүүлэх, дэвшилтэт технологийг ашиглан харилцагч бүрийнхээ санхүүгийн хэрэгцээг цогцоор нь хангах, улмаар ашигт ажиллагааг тогтвортойгоор нэмэгдүүлэх чиглэл барьж ажиллаж байна.

Чингис Хаан банкны нэр хүндийг ажил үйлсээрээ өндөрт өргөн банкны үйлчилгээг хүртээмжтэй хүргэхийн төлөө хичээл зүтгэл гарган ажиллаж буй банкны нийт ажилтнууддаа, бидэнд итгэл хүлээлгэн сонгон үйлчлүүлдэг эрхэм харилцагчид, бизнесийн түншүүд, биднийг үргэлж дэмжин ажилладаг хувьцаа эзэмшигчиддээ талархаж байгаагаа илэрхийлье.

Бидний хамтын ажиллагаа цаашид улам өргөжин тэлж, Монгол улсын банк, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдал, хөгжил дэвшилд том хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байна.

Та бүхний ажил үйлс өөдрөг байж, ашиг орлого тань арвин, амьдрал тань улам цэцэглэн хөгжихийг хүсэн ерөөе!

Хүндэтгэсэн,
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Я.Түвдэндорж

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



Нийт харилцагч, хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэхийн ялдамд, Чингис Хаан банкны 2017 оны ажлын үр дүн, ололт амжилтыг тайлагнаж байгаадаа таатай байна.

Бид банкны стратеги, зорилтын хүрээнд харилцагчдынхаа хэрэгцээнд тулгуурлан эрдэс баялаг, уул уурхай, газар тариалан, хувийн банкны бизнесийн нэгжийг шинээр байгуулан, харилцагчдынхаа санхүүгийн хэрэгцээг нь цогцоор хангах замаар тэдний өсөлтийг дэмжин ажиллалаа.

Тайлант хугацаанд Чингис Хаан банкны харилцах, хадгаламжийн хэмжээ 217,4 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оноос 103 хувь, нийт зээлийн хэмжээ 204,2 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оноос 37 хувиар тус тус өссөн бөгөөд нийт зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн хувь хэмжээ 2016 онд 16 хувь байсныг 2017 онд 8 хувь болгон бууруулж,

Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн ханган ажилласан.

2017 онд банкны нийт актив 399 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оноос 48 хувиар өссөн нь нийт харилцагчдын маань банкинд итгэх итгэл төдийгүй банк амжилттай ажиллахын суурь үндэс болсон хамтын ажиллагааны үр дүн юм.

2017 онд эдийн засгийн хүндрэлийг даван туулах, эдийн засгийн өсөлтийг сэргээх, цаашид тогтвортой өсгөх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн Газар, Монголбанк хамтран ОУВС-ийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд “KPMG” олон улсын аудитын байгууллагаас хийсэн “Активын чанарын үнэлгээ”-нд Чингис Хаан банк хамрагдаж, өөрийн хөрөнгийн хүрэлцээг тодорхойлуулсан бөгөөд цаашдын үйл ажиллагаандаа активын чанараа улам сайжруулах зорилт тавин ажиллаж байна. Мөн харилцагчдынхаа хэрэгцээ шаардлагад нийцсэн, дэвшилтэт технологи дээр суурилсан шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх зорилгынхоо хүрээнд төгрөгийн болон америк долларын олон улсын виза карт, төлбөр тооцооны хялбар шийдэл Q-Pay үйлчилгээг зах зээлд нэвтрүүлснээр цаг хугацаа, орон зайнаас үл хамааран банкны бүх төрлийн үйлчилгээг зайнаас авах боломжийг нийт харилцагчиддаа олгосоор байгааг дуулгахад таатай байна.

Чингис Хаан банкны хувьд өнгөрөгч 2017 он амжилт бүтээлээр арвин жил байсан бөгөөд ирж буй 2018 оныг Монгол улсын эдийн засгийн хувьд өөдрөгөөр төсөөлж, шинэ амжилтуудаар дүүрэн жил болно гэдэгт итгэлтэй байна.

Та бүхний ажил үйлс амжилттай байж, хөгжил дэвшилд хамтдаа тэмүүлэхийн өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлэхийн ялдамд Чингис Хаан банкны удирдлагын баг, нийт ажилтнуудынхаа нэрийн өмнөөс талархал илэрхийлье

Хүндэтгэсэн,
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

С.Сандагдорж

2017 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



ТӨГРӨГИЙН БОЛОН АМЕРИК ДОЛЛАРЫН “VISA” КАРТ

Чингис Хаан Банк, Виза Интернейшнл байгууллагатай хамтран олон улсын стандартад нийцсэн EMV чип бүхий нууцлал, аюулгүй байдлыг бүрэн хангасан, дотоодын болон олон улсын төлбөр тооцоонд ашиглах боломжтой “VISA” нэрийн картыг зах зээлд амжилттай гаргасан.

Q-PAY ҮЙЛЧИЛГЭЭ


Банкны Ckbank аппликейшныг ашиглан өөрийн дансандаа QR код үүсгэн орлого хүлээн авах, төлбөр төлөх боломжтой Q-рау үйлчилгээг банкны үйл ажиллагаанд богино хугацаанд нэвтрүүлж, харилцагчдынхаа төлбөр тооцоо хийх боломжийг хялбаршууллаа.



АКТИВЫН ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ

Эдийн засгийн хүндрэлийг даван туулах, цаашид тогтвортой өсөх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн Газар, Монголбанк хамтран ОУВС-ийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд олон улсын аудитын байгууллагуудаар арилжааны банкуудад хийлгэсэн “Активын чанарын үнэлгээ”-нд Чингис Хаан банк хамрагдаж, өөрийн хөрөнгийн хүрэлцээгээ тодорхойлуулсан.

2017 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



SOBA (СОШИАЛ БАНК)

Монголын банкны салбарт анх удаа Facebook Messenger platform-ыг хиймэл оюун ухаантай хослуулан бүтээсэн, харилцагчын хүссэн асуултанд хариулж, санхүүгийн үйлчилгээ үзүүлэх чадвартай чат ботыг зах зээлд нэвтрүллээ.

ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

Банк харилцагчдынхаа олон улсын төлбөр тооцоог хурдан шуурхай гүйцэтгэх, гадаад худалдааны санхүүжилт олгох болон хил дамнасан хамтын ажиллагааг нь өргөжүүлэх бодлогын хүрээнд 2017 онд шинээр ОХУ-н Связь, Транскапитал, Сбербанк, БНХАУ-н Баошан банк, Өвөрмонголын үндэсний банктai корреспондент харилцаа тогтоож хамтын ажиллагаа, гадаад харилцаагаа улам өргөжүүлэн ажиллалаа.



БИЗНЕСИЙН ШИНЭ ГАЗАР, НЭГЖҮҮД

Харилцагчдынхаа хэрэгцээ шаардлагад нийцсэн банк, санхүүгийн цогц үйлчилгээг хүргэхээр хувийн банк, уул уурхайн хэлтсүүдийг шинээр байгуулахын зэрэгцээ орон нутгийн бизнес эрхлэгчдийг дэмжихээр Сэлэнгэ болон Өмнөговь аймгуудад газар тариалан, эрдэсийн бизнесийн нэгжүүдийг байгуулж, зах зээлийн судалгааны ажлуудыг эхлүүлээд байна.



2017 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЧАНАРЖУУЛАХ

Зээлийн эрсдэлийг бууруулах, үр ашигтай удирдахын тулд “Зээлийн үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг шинэчлэн, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж эхэллээ. Тайлант хугацаанд нийтдээ давхардсан тоогоор 244 харилцагчид 115 тэрбум төгрөгийн цэвэр зээл олгож өнгөрсөн оны зээлийн багцын үлдэгдлийг 216 хувь буюу 77 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн ажиллаж нийт 143.6 тэрбум төгрөгийн зээлийн багцтай болсон ба банкны зээлийн стратеги бодлогын хүрээнд экспортыг дэмжих, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэл, гадаад болон дотоод худалдаа, эдийн засгийн гол хөдөлгөгч салбар болох барилга, уул уурхай, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжин ажиллалаа.



ИТГЭЛ, НАЙДВАР, БОЛОМЖ-2017 БҮХ НИЙТИЙН ГҮЙЛТ

Банк нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэх ажлын хүрээнд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжигч “Achilles International Mongolia” төрийн бус байгууллагаас зохион байгуулдаг “Итгэл, Найдвар, Боломж - Улаанбаатар 2017” бүх нийтийн гүйлтийг уламжлал ёсоор ивээн тэтгэн ажиллалаа. Нийтийг спортод хамруулахад хөгжлийн бэрхшээлтэй хүн бүрийг оролцуулах боломжийг бүрдүүлснээр өөртөө итгэх итгэл, амьдралын чанарыг нь дээшлүүлэх зорилготой тус үйл ажиллагааг зохион байгуулагчтай сүүлийн гурван жилийн хугацаанд тасралтгүй хамтран ажиллаж байна.


КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

Монгол улсын иргэн Д.Батаа, Ш.Бүтэд, Ц.Баярсайхан нарын хөрөнгө оруулалттайгаар 2014 онд байгуулагдсан “Ньюстандарт Финанс” хязгаарлагдмал хариуцлагатай компани нь 2015 онд Чингис Хаан банкны хувьцааг худалдан авснаар банк 100 хувь үндэсний хөрөнгө оруулалттай банк болсон. “Ньюстандарт Финанс” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн өмчлөл нь дараах бүтэцтэй.

НЬЮСТАНДАРТ ФИНАНС ХХК

=



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД


Чингис Хаан Банкны Төлөөлөн удирдах зөвлөл нь Монгол улсын банкны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2, Чингис Хаан Банкны компанийн дүрмийн 4.3.2-т заасны дагуу дарга-1, гишүүн-3, хараат бус гишүүн-1 гэсэн 5 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд:

ТУЗ-ийн дарга: Я.Түвдэндорж

ТУЗ-ийн гишүүд: Ш.Бүтэд, Д.Батаа, Ц.Баярсайхан

ТУЗ-ийн хараат бус гишүүн: Д.Чимэддавга



ДОТООД ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

Банкны дээд удирдлага буюу төлөөлөн удирдах зөвлөлөөс банкны үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлэх үүднээс банкны дотоод хяналтын тогтолцоог дараах хэсгүүдээс бүрдүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Ажиллагсдын эрхэмлэх үнэт зүйлс, ёс зүйн хэм хэмжээ;
- Удирдлагын бодлого;
- Банкны бүтэц, зохион байгуулалт;
- Удирдлага болон ажиллагсдын шатлан захирах эрх хэмжээ, хариуцлагын хуваарилалтын оновчтой хэлбэр;
- Хүний нөөцийг удирдах бодлого;
- Хүний нөөцийн мэдлэг чадварын хэм хэмжээ.

Банкны дотоод хяналтын тогтолцоо, түүний үйл явцад удирдлагын зүгээс тавих хяналт нь тавьсан зорилт, төсөв төлөвлөгөөний биелэлт, санхүүгийн үзүүлэлтүүдийн үр дүнгийн талаар тухайн асуудлыг хариуцсан албан тушаалтнууд Банкны ТУЗ, Гүйцэтгэх захиралд байнга тайлагнан танилцуулж байх, удирдлагаас тэдэнд асуулга тавьж, тодруулга гаргуулах, тайлбар авах замаар бодит байдлыг шалгаж, зөрчил, алдаа дутагдлыг илрүүлэх, эдгээрийн үр дүнд цаашид авах арга хэмжээг тодорхойлох хэлбэрээр хэрэгжиж байна. Банкны удирдлага болон ажилтнууд нь банкны дотоод хяналтын тогтолцоонд дараах үүрэгтэйгээр оролцдог.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Банкны дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын тогтолцоог банкны үйл ажиллагааны хэм, хэмжээг харгалзан зохистой бүрдүүлэх, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлт болон Монголбанкны хяналт шалгалтын акт материал, түүний үнэлэлт дүгнэлтийн дагуу банкны үйл ажиллагаанд гарч буй доголдол, зөрчил дутагдлыг арилгах талаар Гүйцэтгэх захирлын хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, арга хэмжээ нь шаардлага хангахуйц, үр дүнтэй байгаа болон дотоод хяналтын тогтолцоо нь банкны бүх төрлийн эрсдэлийг илрүүлэх, түүнийг бууруулахад эерэг, зохистой нөлөөлөл үзүүлж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллаж байна. Тайлант жилд ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааг идэвхжүүлэхэд чиглүүлэн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж, тэдгээрийн ажиллах журмуудыг банкны үйл ажиллагаанд зохицуулан шинэчлэн боловсруулах арга хэмжээ авлаа.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Гүйцэтгэх захирал нь банкны бүтэц, зохион байгуулалтын дагуу нэгжүүдийн удирдлага болон нийт ажилтнуудын эрх үүрэг, хариуцлагыг харилцан уялдаатай, оновчтой, тодорхой байхаар зохион байгуулах, ТУЗ-өөс олгогдсон эрхийн хэмжээнд ашигт ажиллагаатай уялдуулан үйл ажиллагаатай холбоотой дотоод журам, заавруудыг батлах, хэрэгжилтийг хянах, дотоод аудитын дүгнэлт болон Монголбанкны хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар банкны холбогдох ажилтнуудад үүрэг даалгавар өгөх, хэрэгжилтийг нь хянах замаар өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллаж байна.

ДОТООД ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

ГАЗАР НЭГЖҮҮДИЙН УДИРДЛАГА

Банкны газар, хэлтсийн захирлууд нь өөрийн нэгжийн ажилтан бүрийн хариуцах ажил, хүлээх хариуцлагыг үйл ажиллагааны бодлого, журам, заавар, ажил үүргийн тодорхойлолтод тодорхой заан өгч, үйл ажиллагааны шат бүрд дараалсан хяналттай байхаар зохион байгуулах, дотоод хяналтын үйл ажиллагааны ач холбогдлыг ойлгуулж, үйл ажиллагааны түвшин бүрд хяналт тавьж хэвшүүлэн, зарчимч шударга байдлыг дэмжих чиглэлээр ажилладаг.


БАНКНЫ АЖИЛТАН

Ажилтнууд банкны дотоодод нийтээр мөрдөгдөх дүрэм, журам заавар болон хариуцсан ажлын чиглэлээр мөрдөгдөх бодлого, журам заавруудыг өдөр тутам хэрэгжүүлэх замаар дотоод хяналтын тогтолцоонд оролцдог.

МУ-Н ЭДИЙН ЗАСГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД


Эдийн засгийн хүндрэлийг даван туулах, эдийн засгийн өсөлтийг сэргээх, цаашид тогтвортой өсгөх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газар, Монголбанк хамтран ОУВС-ийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-т 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдрөөс хамрагдан, макро эдийн засгийн цогц бодлогоо тодорхойлон, үйл ажиллагаагаа эрчимжүүлэн ажилласан. Хөтөлбөрийн үндсэн зорилтын хүрээнд эдийн засгийг богино хугацаанд тогтворжуулж, урт хугацаанд хүртээмжтэй эдийн засгийн өсөлтийг бий болгох замаар үр дүнгээ өгч байгаа нь банкны салбарын үйл ажиллагаа тогтвортой, найдвартай байх үндсэн нөхцөлийг бүрдүүлсэн байна.

ТӨСВИЙН ТЭНЦЭЛ /Хэмжих нэгж: тэрбум.төг/




Улсын нэгдсэн төсвийн орлого өнгөрсөн жилийн мөн үеэс 23.7 хувиар өсч, зарлага 5.7 хувиар буурсан бол төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл өнгөрсөн оны мөн үеэс 52,5 хувь буурсан нь засгийн газрын бондын зээлийн санхүүжилт, эргэн төлөлттэй холбоотой ба тус онд төсвийн тэнцэл 1,741 тэрбум төгрөгийн алдагдалтай гарав.

ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН /Хэмжих нэгж: тэрбум.төг/




Дотоодын нийт бүтээгдэхүүн 2017 оны байдлаар 27 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 3 их наяд төгрөгөөр буюу 13 хувиар өсч эдийн засгийн өсөлт 5.1%-т хүрэв.

ВАЛЮТЫН ХАНШ




2017 оны 11-р сард гадаад валютын нөөц 2.2 тэрбум ам.доллар болж өнгөрсөн оны мөн үеэс 75.7% нэмэгдсэн үзүүлэлт нь ОУВС-ийн хөтөлбөр, гадаад өрийн хугацааг хойшлуулсан, төлбөрийн тэнцлийн алдагдал буурсантай холбоотой ба урт хугацаанд макро эдийн засгийн хүрээнд илүү эерэг нөхцөл байдлыг бүрдүүлэх хүлээлттэй байна.

ИНФЛЯЦИЙН ТҮВШИН




Төрөөс мөнгөний бодлогын талаар 2017 онд баримтлах үндсэн чиглэлд инфляцийг 8 хувиас дээшгүй түвшинд байлгах зорилтыг тавьсан ба оны эхэнд 0.5 хувь байсан ХҮИ-ээр илэрхийлсэн инфляци 2017 оны туршид өсч, оны эцэст улсын хэмжээнд 6.4 хувьд хүрч зорилтот хэмжээнд барьсан байна.

ГАДААД ХУДАЛДАА




Нийт барааны эргэлт 2017 оны байдлаар 10.5 тэрбум төгрөг буюу 27% өсөв. Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл, нийт бараа эргэлтийн 63% буюу 6,681 сая ам.долларын худалдааг БНХАУ улстай, 12% буюу 1,284 сая ам.долларын худалдааг ОХУ-тай хийжээ. Тус онд уул уурхайн түүхий эдийн экспортын өсөлт өндөр гарсан нь экспорт өмнөх сараас 6.2%, импорт 0.7% буурч худалдааны тэнцэл 1865 сая ам.долларын ашигтай гарах гол хүчин зүйл болсон байна.

БАНКНЫ САЛБАРЫН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД




Тайлант онд банкны салбарын нийт хөрөнгө 28,8 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 13,6% өслөө. Нийт хөрөнгө 2013 оноос хойш жилд дунджаар 8,3% өссөн бол сүүлийн таван жилийн хугацаанд өөрийн хөрөнгө хоёр дахин өссөн байна.

■ Нийт актив
■ Өөрийн хөрөнгө




2017 оны эцсийн байдлаар банкны салбарын өөрийн хөрөнгийн хүрэлцээ 17.4%, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт 42,2% байгаа нь зохистой харьцааны шалгуур үзүүлэлтээс 5,4 болон 17,2 нэгжээр давуулан биелүүлж Монголбанкны тавьсан шалгуурыг бүрэн хангаж ажилласан байна.

■ Өөрийн хөрөнгийн хүрэлцээ %
—○— Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар %



Чанаргүй зээлийн багцад эзлэх хувь 8.6% буюу өмнөх оны түвшинд байсан ба багцын үлдэгдэл 1,148 тэрбум төгрөг байгаа нь 2016 оноос 9,6% өссөн үзүүлэлттэй байна.


■ Чанаргүй зээл %
—○— Эрсдэл даах чадвар %




2017 онд банкны салбар 252,5 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь өмнөх онтой харьцуулахад өсч, 2015 оны түвшинд хүрсэн байна. Хэдийгээр өөрийн хөрөнгийн өгөөж өсч 8,2% хүрсэн хэдий ч засгийн газрын үнэт цаасны хүүнээс доогуур түвшинд байна.

■ Цэвэр ашиг
—○— Өөрийн хөрөнгийн өгөөж %


ЧИНГИС ХААН БАНКНЫ САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ




Банкны нийт актив 129 тэрбум төгрөгөөр нэмэгдэн 399 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны эцсээс 48 хувиар өсөв.



Банкны өөрийн хөрөнгийн хэмжээ 33 тэрбум төгрөгт хүрсэн. Банк өөрийн хөрөнгийн хүрэлцээний шалгуурыг тогтмол ханган ажиллаж байна.



Нийт харилцах, хадгаламж 110 тэрбум төгрөгөөр нэмэгдэн 216 тэрбум төгрөгт хүрч, 2016 оны жилийн эцэстэй харьцуулахад 104 %-иар өссөн.



2017 онд 115 тэрбум төгрөгийн зээл олгож зээлийн багц 77 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, чанаргүй зээлийн түвшин 16.7%-иас 9.1% болж буурав.

ЧИНГИС ХААН БАНКНЫ ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Шалгуур үзүүлэлт	Байвал зохих	Биелэлт /Оны эцсийн байдлаар/	
		2016	2017
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа	>9%	13.0%	11.5%
Өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын хөрөнгө	>12%	13.0%	12.8%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт	>25%	28.3%	33.5%
Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (нэгж валютаар)	<15%	5.4%	15.1%
Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (нийт)	<40%	6.9%	15.1%

Чингис Хаан банк Монголбанкнаас гаргасан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтмол ханган ажиллаж байна.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Чингис хаан банкны эрсдэлийн удирдлага нь банкны үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, урьдчилан сэргийлэх, хянах замаар банкны хүлээж болзошгүй хохирлыг бууруулах, ашиг сонирхлын зөрчлөөс хараат бус байж, эрсдэлийн удирдлагын үр ашигтай тогтолцоог бий болгож хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ. Энэ нь банкны зорилго, зорилтуудыг амжилттай биелүүлэх гол үндэс суурь бөгөөд банкны нийт ажилтан бүрд эрсдэлийг ухамсарлах сэтгэлгээг төлөвшүүлж эрсдэлийн соёлыг бий болгох, түгээх, эрсдэлд суурилсан засаглалыг тогтоох, бэхжүүлэх чухал ач холбогдолтой. Банкны эрсдэлийн удирдлагын хүрээнд зээлийн эрсдэл, үйл ажиллагаа, зах зээл, комплаенсийн эрсдэл зэргээр ангилж удирдан зохион байгуулж ажиллаж байна.

2017 оны эрсдэлийн удирдлагын хэрэгжилт

01

Зээлийн эрсдэлийн удирдлагын чиглэлээр

“Зээлийн бодлого”, “Зээлийн үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг шинэчлэн боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсэгт оролцож бодлого, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.

Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын чиглэлээр

Банкны үйл ажиллагааны эрсдэлийн үнэлгээг банкны ажилтан бүрийн тодорхойлсон эрсдэл хяналтын өөрийн үнэлгээнд суурилан эрсдэлийн матрицын аргыг ашиглан хийж холбогдох зөвлөмжүүдийг боловсруулан шаардлагатай арга хэмжээг авч ажилласан.

ISO27001 олон улсын стандарттай нийцүүлэн баталсан “Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн удирдлагын журам”-ын дагуу банкны мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг бүх газар, нэгжүүдийн мэдээллийн хөрөнгийг ангилж, тэдгээрийн эмзэг байдал, аюул заналын нөлөөнд үндэслэн эрсдэлийн түвшинг тодорхойлж, эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг боловсруулсан.

02

Зах зээлийн эрсдэлийн удирдлагын чиглэлээр

Зах зээлийн эрсдэлийг тооцох аргачлалыг боловсронгуй болгох зорилгоор VaR-ийг түүхэн үүсгэврийн арга, Монтекарло симуляци, Вариаци ковариаци зэрэг аргуудаар тооцож, багцын эрсдэлийг тооцоход копула функцыг хэрэглэж тооцооллын үр дүнг харьцуулах боломжтой байхаар өргөтгөсөн.

03

Банкны 2018 онд баримтлах эрсдэлийн удирдлагын стратегийг банкны эрсдэлийн удирдлагын шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлон тэдгээрийг ханган ажиллах замаар нийт хүлээж болзошгүй алдагдлыг бууруулах зорилгоор хүү, хөрвөх чадвар, гадаад валютын ханшийн эрсдэлүүдийг хамруулан боловсруулсан.

Бусад чиглэлээр

Комплаенсийн эрсдэлийг бууруулах чиглэлээр банкны үндсэн бүртгэлийн NES системд “Хар дэвтэр” модулийг нэвтрүүлж, сэжигтэй гүйлгээг автоматаар илрүүлэх боломжтой болсон. NES системийн “Полиси” модулийг ашиглан оффшор бүсэд хийгдэж буй гадаад гуйвуулгын гүйлгээг нэгжийн ажилтны оролцоогүйгээр комплаенсийн ажилтан шууд хянах боломжтой болсон.

04

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Эрсдэлийн засаглалын тогтолцоо:



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН УДИРДЛАГА

Мэдээллийн технологийн олон улсын стандарт, шаардлагуудыг хангасан мэдээллийн технологи, техник хэрэгслүүдийг ашиглан банкны үйлчилгээг харилцагчдад чанартай, түргэн шуурхай эрсдэлгүй хүргэх, дотоод үйл ажиллагааг автоматжуулж, ажилтнуудынхаа хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэхэд анхаарч, банкны суурь бүртгэлийн системийн тогтвортой, найдвартай байдлыг нэмэгдүүлэх, сервер тоног төхөөрөмж, сүлжээ бүхий мэдээллийн технологийн дэд бүтцийг шинэчлэн зохион байгуулж, шинэлэг цахим бүтээгдэхүүн хөгжүүлэх зэрэг ажлуудыг хэрэгжүүлэн ажиллалаа.

2017 онд мэдээлэл технологийн чиглэлээр хэрэгжүүлсэн ажлууд

Банкны суурь бүртгэлийн систем: 2016 онд Банкны үндсэн бүртгэлийн системээ шинэчлэн “Грэйп Сити Монгол” компаниас хөгжүүлэн гаргасан NES банкны бүртгэлийн системийг нэвтрүүлсэн анхны банк болсон. Тайлант онд активын чанарын үнэлгээний багийнханд мэдээлэл бэлтгэн хүргэх T2A, T4A DIV програм хангамжийг богино хугацаанд хөгжүүлэн банкны үндсэн бүртгэлийн системтэй холбон ажиллуулалаа.

Дотоод үйл ажиллагааг автоматжуулах: Банкны дотоод үйл ажиллагааг автоматжуулах, цаасгүй технологийг нэвтрүүлэх зорилт тавин сүүлийн үеийн технологи болох “ODOO ERP” системийг дотоодын нөөц бололцоогоор үе шаттайгаар нэвтрүүлэн, хөгжүүлэлтийг хийж эхэлсэн. Мөн дотоод харилцаа холбоондоо Microsoft-ийн Exchange, Skype, дотоодын E-office системийн сайжруулалт гэх зэрэг харилцааны системүүдийг нэвтрүүлэн ажилтнуудын бүтээмжит ажиллагааг дэмжиж ажиллалаа.

Дэвшилтэт технологи: SOBA (сошиал банк) үйлчилгээ нь Монголын банкны салбарт анх удаа Facebook Messenger platform-ыг хиймэл оюун ухаантай хослуулан бүтээсэн, харилцагчын хүссэн асуултанд хариулж, санхүүгийн үйлчилгээ үзүүлэх чадвартай чаат бот юм.

Цахим банкны үйлчилгээ нь харилцагчдын хүсэл зорилгод нийцсэн, орчин үеийн техник технологийн дэвшилд тулгуурласан цахим сувгийн үйлчилгээнүүд болох интернэт банк, мобайл банк систем дээрээ цалингийн багц гүйлгээ хийх, QR технологи дээр суурилсан Q-руу үйлчилгээ, картаар үйлчлэгч байгууллагын дансны хуулга харах, картын сүлжээгүй орчинд байгууллагын гүйлгээ саадгүй хийгддэг болсон зэрэг нэмэлт сайжруулалт, хөгжүүлэлтүүдийг хийн ажиллалаа.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГА

Чингис Хаан Банкны ТУЗ-ийн тогтоолоор 2017 онд банкны бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн баталж, банкны бүтээгдэхүүн үйлчилгээ хүргэх, үйл ажиллагааг дэмжих, хянах үүрэг бүхий зохион байгуулалтын цогц бүтцийг бий болголоо. Энэхүү бүтцийн дагуу банк нь 8 газар, 16 хэлтэс, 1 салбартай үйл ажиллагаагаа явуулж байна. Тайлант онд “Цахим бизнесийн судалгаа, хөгжлийн хэлтэс”, “Бизнес хөгжлийн газар”, “Хувийн банкны хэлтэс”, “Уул уурхайн бизнесийн хэлтэс”, “Эрдэсийн бизнесийн нэгж/хэлтэс”, “Газар тариалангийн бизнесийн нэгж/хэлтэс”-ийг шинээр байгуулж, холбогдох газар нэгжийн чиг үүрэг, ажилтнуудын ажил үүргийн тодорхойлолтыг баталгаажуулах, боловсон хүчнийг сонгох, бэлтгэх, сургах ажлыг хэрэгжүүлсэн.



Ажилтнуудын мэргэжлийн ур чадвар, манлайлал, өрсөлдөх чадвар, ажлын бүтээмж, хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэгдсэн сургалт, хөгжлийн ажилд

101 ажилтан хамрагдсан.

2017 онд хүний нөөцийн газар нь мэдээллийн технологийн хэлтэстэй хамтран вэбэд суурилсан ERP системийн хүний нөөцийн шинэ модулийг нэвтрүүлснээр ажилтнуудын мэдээлэл болон амралт, чөлөөний хүсэлтийг шийдвэрлэсэн байдал, ирц бүртгэлийг програмын түвшинд харах, хянах, тайлагнах ажил боловсронгуй болж, цаашид хүний нөөцийн мэдээ тайлангуудыг сайжруулах, автоматжуулах ажлуудыг санаачлан хийж байна.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

Чингис Хаан Банк олон улсад нэр хүндтэй банк, санхүүгийн байгууллагуудтай хамтран ажилласаар ирсэн бөгөөд одоогийн байдлаар 4 улсын 9 банктай харилцаа, хамтын ажиллагаатай ажиллаж байна. Өнгөрсөн онд ОХУ-ын Связь, Транскапитал, Сбербанк хамтын ажиллагааг эхлүүлж, рубль, евро, ам.долларын, иены ностро данс, Өвөрмонголын үндэсний банкинд доллар, юаны дансыг тус тус нээж, гадаад төлбөр тооцооны үйл ажиллагаагаа өргөтгөхийн зэрэгцээ олон улсын төлбөр тооцооны хамгийн өргөн сүлжээ бүхий S.W.I.F.T сүлжээг ашиглан харилцагчдынхаа гадаад төлбөр тооцоог шуурхай гүйцэтгэж байна.

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА



Чингис Хаан банк нь нийгмийн хариуцлагынхаа хүрээнд "Achilles International Mongolia" олон улсын төрийн бус байгууллагаас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог сайжруулах зорилгоор жил бүр зохион байгуулдаг "Итгэл найдвар, Боломж Улаанбаатар-2017" бүх нийтийн марафон гүйлтийн тэмцээнд 3 дахь жилдээ хамтран ажиллалаа. Чингис Хаан Банк нь тус марафоныг анх зохион байгуулагдсан цагаас нь эхлэн дэмжиж ирсэн бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэх үйлст өөрийн хувь нэмрээ оруулан ажилласаар байна.

Тайланд улсын Мак Сон хотод дэлхийн чансааны эхний 10-т яваа шилдэг тамирчдыг оролцуулдаг хүндийн өргөлтийн дэлхийн цомын тэмцээнд Монгол улсаа төлөөлөн оролцох хүндийн өргөлтийн үндэсний шигшээ багийн тамирчин ОУХМ, Ази тивийн аварга Э.Билэгсайханыг ивээн тэтгэн хамтран ажиллалаа.





ЧИНГИС ХААН
БАНК

ХОЛБОО БАРИХ



(976) 7510-5555



bank@ckbank.mn



www.ckbank.mn

БАНКНЫ АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**2017 оны 12 сарын 31 -ний өдрөөр тасалбар болсон жилийн
санхүүгийн тайлан бэлтгэх болон батлах талаарх
Удирдлагын хариуцлагын мэдэгдэл**

Энэхүү тайлангийн хараат бус аудиторын тайланд дурдсан хараат бус аудиторын дүгнэлттэй хамт уншигдах дараах мэдэгдэл нь "ЧИНГИС ХААН БАНК" ХХК-ийн (цаашид "Банк" гэх) 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага болон аудиторын хариуцлагыг тусад нь илэрхийлэх үүднээс хийгдсэн болно.

"ЧИНГИС ХААН БАНК" ХХК-ийн удирдлага бид эдгээр санхүүгийн тайлангуудыг СТОУС болон түүнд нийцүүлэн, гаргасан нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой хууль, заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Банкны удирдлага нь Банкны санхүүгийн тайлан тодруулга 2 ба 3-т дурдсан шаардлагуудад нийцсэн гэдгийг баталгаажуулах боломжийг хангах, санхүүгийн байдлыг үндэслэлтэй, үнэн зөвөөр илэрхийлж чадах зөв зохистой нягтлан бодох бүртгэлийг хөтөлж бэлтгэсэн гэдгийг баталгаажуулах үүрэгтэй.

Мөн удирдлага нь Банкны эд хөрөнгийг хадгалан хамгаалах, аливаа залилан ашиглал, зүй бус үйлдлээс сэргийлэх, ийм үйлдэл гарвал илрүүлэхэд шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх ерөнхий үүрэгтэй.

Банкны удирдлага нь 6-51 дугаар хуудсанд илэрхийлсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ тохиромжтой нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгон, тууштайгаар мөрдөж, үндэслэлтэй, нягт нямбай тооцоолол, үнэлгээ хийн, холбогдох бүх нягтлан бодох бүртгэлийн стандартыг мөрдсөн гэж үзэж байна.

Банкны удирдлагаас "ЧИНГИС ХААН БАНК" ХХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн санхүүгийн тайланг зөвшөөрч батлав.



Огноо: _____

Г.Батбаяр
Санхүү хариуцсан захирал

Огноо: 2018.02.29

Улаанбаатар хот



АУДИТ
БАТАЛГААЖУУЛАЛТ
ҮЙЛЧЛЭГЭЭ

Монголын Бухалч, Рейтинг, Аудит ХХК
УБ, Саянзүрх дүүрэг, 6-д хороо
Баруунд МН ХХК-ийн өсрөм: 303
Утас: 976-7000-5329
Гар утас: 976-9985-1823
И-мэйл: mbr.audit.80@gmail.com

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

"ЧИНГИС ХААН БАНК" ХХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

Зөрчилгүй дүгнэлт

Бид "Чингис хаан банк" ХХК (цаашид "Банк" гэх)-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-нээрх тусдаа санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болсон жилийн тусдаа орлогын дэлгэрэнгүй тайлан, тусдаа өмчийн өөрчлөлтийн тайлан, тусдаа мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын хураангуй, бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлан (цаашид "санхүүгийн тайлан" гэх)-д аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр "Чингис хаан банк" ХХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал ба уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн Сайдын хамтарсан тушаалаар батлагдсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

Зөрчилгүй дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)-уудын дагуу хийж, гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулав.

Бид Нягтлан бодогчдын ёс зүйн Олон улсын стандартын зөвлөлийн Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн зохих шаардлагуудын дагуу тус Банкнаас хараат бус бөгөөд эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

Онцлох асуудал

Аудитын онцлох асуудлууд гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлийн хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайланд үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байдаг ба эдгээр асуудлуудыг санхүүгийн тайлангийн аудитын агуулгын хүрээнд бүхэлд нь болон аудиторын дүгнэлт гаргахад авч үзсэн бөгөөд эдгээр асуудлуудын улмаас бид дүгнэлтээ хязгаарлаагүй болно. 2017 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой онцлох асуудлын дэлгэрэнгүйг тодруулга 34-д харуулав.

Тасралтгүй үйл ажиллагаа

Бид банкны үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлэх чадамжтай холбоотой тодорхой бус байдлын талаар энэхүү тайлангийн тодруулга 33-д дурдсан.

Бусад асуудал

Банкны Гүйцэтгэх захирлын 2015 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 157 дугаар тушаалаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг шинэчлэн баталж, 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөхөөр заасан.

Банк нь 2017 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2015 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн А35/20 дугаар хамтарсан тушаалаар шинэчлэн батлагдсан Нягтлан



АУДИТ
БАТАЛГААЖУУЛАЛТ
ҮЙЛЧИЛГЭЭ

Монголын Бизнес Рейтинг Аудит ХХК
УБ, Баянзүрх дүүрэг, 6-р хороо
Барилга МН ХХК-ийн барилга 303
Утас: 976-7000-5329
Гар утас: 976-9985-1823
И-мэйл: mor.audit.lic@gmail.com

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ (үргэлжлэл)

Бодох бүртгэлийн багц материалын дагуу санхүүгийн тайлангаа бэлтгэсэн талаарх дэлгэрэнгүй тодруулгыг 38-д харуулсан.

Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн Санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Банкны удирдлага эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан заавар, журмын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэгтэй. Удирдлагын тодорхойлох энэхүү дотоод хяналт нь санхүүгийн тайланг аливаа алдаа эсвэл залилангийн улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай байдаг.

Удирдлага нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ Банкны үйл ажиллагааг зогсоох юмуу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах Банкны чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Банкны санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн тайлагналын аудитад хүлээх аудиторовн үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайланг нь бүхэлдээ ангид эсэх талаарх үл үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторовн тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

АОУС-ын дагуух аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан ажилладаг. Үүнд:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно. Банкны дотоод хяналтын үр ашгийг байдлад дүгнэлт өгөх зорилгоор буюу тухайн нөхцөл байдлад тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Ашиглагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын нийцэмжтэй байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын үл үндэслэл, удирдлагын гаргасан холбогдох тодруулгыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Банкны тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн



АУДИТ
БАТАЛГААЖУУЛАЛТ
ҮЙЛЧИЛГЭЭ

Монголын Бизнес Рейтинг Аудит ХХК
УБ, Баянзүрх дүүрэг, 6-р хороо
Барилга МН ХХК-ийн барилга 303
Утас: 976-7000-5329
Гар утас: 976-9985-1823
И-мэйл: mor.audit.lic@gmail.com

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ (үргэлжлэл)

явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторовн тайландээ санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторовн тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал Банк тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.

- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн өрөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар гол гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцдаг.

Бид хараат бус байдлын талаар холбогдох өс зүйн шаардлагуудад нийцсэн гэдгээ засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдэд мэдэгддэг ба мөн бид тэдгээр хүмүүстэй бүх харилцаа холбоо болон шаардлагатай гэж үзвэл холбогдох хамгаалалт зэрэг бидний хараат бус байдлын хүрээнд бодолцож үзвэл зохих асуудлуудаар харилцдаг.

Бусад хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагын талаарх тайлан

Банк нь өөрийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн дагуу тооцохдоо Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 7 дугаар сарын 30-ны 480 тоот тушаалаар батлагдсан "Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам"-ыг мөрдөж байна.

Журамд заасны дагуу банк нь өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа, зээлийн төвлөрлийн эрсдэлийн зохистой харьцаа, гадаад валютын ханшийн эрсдэлийн зохистой харьцаа зэргийг хэрхэн хангаж байгааг энэхүү тайлангийн Тодруулга 32-д харуулсан.

Бусад

Банкны 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайлангийн аудитыг Улаанбаатар аудит корпораци ХХК гүйцэтгэж, уг тайланд 2017 оны 3 дугаар сарын 29-ний өдөр аудиторовн зөрчилгүй дүгнэлт гаргасан болно. 2017 оны санхүүгийн тайлангийн зэрэгцүүлэх мэдээлэл нь уг зөрчилгүй дүгнэлт бүхий санхүүгийн тайланд үндэслэсэн.

Энэхүү Хараат бус аудиторовн тайланг гаргахад оролцсон гэрээт ажлын Партнер нь Дашхүүгийн Түмэнжаргал болно.

Д.Түмэнжаргал Ерөнхий захирал,
Монголын Бизнес Рейтинг Аудит ХХК
Улаанбаатар хот, Монгол Улс

Огноо: 2018.03.29

Санхүүгийн байдлын тайлан /2017 оны 12 сарын 31/:

(Мянган.төгрөг)

Хөрөнгө	
Эргэлтийн хөрөнгө	
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	86,319,376
Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	36,598,515
Хөрөнгө оруулалт	40,653,321
Зээл	204,290,836
Бусад санхүүгийн хөрөнгө	2,686,874
Бусад санхүүгийн бус хөрөнгө	11,717,398
Үндсэн хөрөнгө	16,100,608
Биет бус хөрөнгө	667,477
Нийт хөрөнгө	399,034,405
Өр төлбөр ба эздийн өмч	
Харилцах	139,805,140
Хадгаламж	77,591,149
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	111,454,118
Бусад эх үүсвэр	35,714,275
Бусад санхүүгийн өр төлбөр	1,449,413
Бусад санхүүгийн бус өр төлбөр	20,344
Нийт өр төлбөр	366,034,438
Эздийн өмч	
Хувь нийлүүлсэн хөрөнгө	47,983,740
Нэмж төлөгдсөн капитал	0
Дахин үнэлгээний нэмэгдэл	3,400,000
Хуримтлагдсан ашиг	(18,383,774)
	32,999,966
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	399,034,405

Орлогын дэлгэрэнгүй тайлан /2017 оны 12 сарын 31/

(Мянган.төгрөг)

Хүүний орлого	29,570,149
Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	393,146
Үнэт цаасны	2,499,209
Зээлийн	26,453,223
Бусад хүүний орлого	224,570
Хүүний зардал	24,720,169
Харилцахад төлсөн хүү	7,169,607
Хадгаламжинд төлсөн хүү	15,827,064
Зээлийн хүүний зардал	1,166,193
Үнэт цаасны хүүний зардал	548,566
Бусад хүүний зардал	8,739
Хүүний цэвэр орлого	4,849,980
Эрсдэлийн сангийн зардал	826,095
Үнэт цаасны	-
Зээлийн	826,095
Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого	4,023,886
Бусад орлого	6,228,230
Хүүний бус орлого	5,643,230
Арилжааны орлого	1,431,786
Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого	1,727,457
Банкны бүтээгдэхүүнтэй холбоотой үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	2,093,440
Бусад хүүний бус орлого	400,354
Бусад орлого, олз	575,193
Бусад зардал	13,526,282
Хүүгийн бус зардал	13,002,706
Бусад эрсдэлийн сангийн зардал	-
Арилжааны зардал	2,393,402
Ханш, үнэлгээний тэгшитгэлийн зардал	1,167,928
Хураамж, шимтгэлийн зардал	191,346
Үйл ажиллагааны бусад зардал	9,250,030
Бусад зардал, гарз	523,577
Татварын өмнөх ашиг, алдагдал	(3,274,167)
Орлогын татварын зардал	-
Татварын дараах ашиг, алдагдал	(3,274,167)